



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/100

Бодь

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол улсын орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөвт албан байгууллагуудын хоол хүнсний материал, шатахуун тослох материал нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгох тендерийг багц болгон сумын хэмжээнд зохион байгуулах, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Н.Сумъяа - А-3 сертификатай
Нарийн бичгийн дарга	Б.Алтанхуяг - А-3 сертификатай
Гишүүд	А.Лхагвабаяр - А-3 сертификатай
	Г.Буянжаргал - А-3 сертификатай
	Г.Оюунсүрэн - А-3 сертификатай
	Б.Цэдэвсүрэн - Орон нутгийн төлөөлөл
	Т.Цэнд-Аюуш - Сан хариуцсан нягтлан бодогч

2.Тендерийн урилга, тендер хүлээн авах, нээх ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй, шударга, зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Сумъяа)-д үүрэг болгосугай

3.Худалдан авах ажиллагааны тендерийг шалгаруулахдаа орон нутагт бүтээгдэхүүн үйлдвэрлэж үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

642201195

4. Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэрээ 2022 оны 10 дугаар сарын 30-ны дотор сумын Засаг даргад танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Сумъяа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ